

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар: 04

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.2.6.ж, 2022 оны 558 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ын 2.2, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “Эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал”-ын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо (Я.Батханд)-нд тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



ЭРСДЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРАА ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх арга, аргачлалыг тогтоох, учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлох, хэмжих, зохицтойгоор удирдах, хянах, тайлагнахтай холбоотой харилцааг энэ аргачлалаар зохицуулна.

1.2. Энэ аргачлал нь компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Эрсдэлийн үнэлгээний аргачлалд тавигдах шаардлага

2.1. Эрсдэлийн үнэлгээний аргачлал нь компанийн бүтэц, зохион байгуулалт, эрсдэлийн удирдлагын стратегид тохирсон байх ба бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, цар хүрээ, харилцан хамааралтай шинж чанарыг харгалzan хамгийн тохиромжтой бөгөөд хангалттай арга, техникийг ашиглана.

2.2. Эрсдэлийн үнэлгээний аргачлалд дараах зүйлийг тусгана:

(Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

2.2.1. Эдийн засаг, зах зээлийн төсөөлөл, тэдгээрээс компанийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл;

2.2.2. Компанийн бизнесийн орчинд оролцогчид (Төлөөлөн удирдах зөвлөл, удирдах албан тушаалтан, ажилтан, даатгагч, даатгуулагч, олон улсын давхар даатгагч, хамтран ажилладаг болон хянан шалгадаг, зохицуулагч байгууллага)-ын үйл ажиллагаа, зорилго, зорилт, эрх ашгийн нөлөөлөл;

2.2.3. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн байдал, зохицуулалтад орох өөрчлөлт, шинэчлэлийн нөлөөлөл;

2.2.4. Компанийн бүтэц, зохион байгуулалт, соёл, хүний нөөцийн нөлөөлөл;

2.2.5. Эрхэлж буй даатгалын төрөл, хэлбэр, төвлөрлийн байдлын талаар;

2.2.6. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, удирдах, бууруулах арга замын талаар.

2.3. Компани макро, микро эдийн засгийн хүчин зүйл, даатгагчийн бизнесийн стратеги болон бусад гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс үүдэн компанийд үүсэж болзошгүй эрсдэлийг стресс тест, эмзэг байдлын шинжилгээ, урвуу тест болон бусад шинжилгээний арга аргачлалыг ашиглан дүгнэлт хийсэн байх шаардлагатай.

2.4. Компани нь даатгалын хэлбэр болон тэдгээрийн эзлэх хувь ба төвлөрлийн байдлыг тооцоолон хянана.

2.5. Компани нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон даатгалын нөөц сангийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос тогтоосон зайлшгүй байх хөрөнгө болон нөөц сангийн тооцоололд тавигдах шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана.

2.6. Компани нь өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлантай холбоотойгоор компанийн бизнес төлөвлөгөө, андеррайтинг, давхар даатгал, хөрөнгийн удирдлагатай холбогдох төлөвлөгөө, баримт бичигт өөрчлөлт оруулах тохиолдолд энэ талаар үнэлгээний тайланд заавал тусгаж, эдгээр баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулна.

Гурав. Эрсдэлийг үнэлэх арга, аргачлал

3.1. Даатгалын эрсдэлийг үнэлснээр компани нь даатгагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох бөгөөд Хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын” 2 дугаар зүйлд заасны дагуу тооцоолж, эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцаагаар илэрхийлнэ.

(Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

3.2. Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар тооцсон төлбөрийн чадварын зохистой харьцааг энэ аргачлалын 3.1-д заасан журмын 2.19-д заасны дагуу ангилах бөгөөд төлбөрийн чадварын түвшингээс хамааран тус журмын 4 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

(Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

3.3. Даатгалын бус эрсдэлийг үнэлснээр компанийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх чадвар, гадаад, дотоод орчны эрсдэлийг удирдах стратегитай эсэхийг тодорхойлох бөгөөд тухайн эрсдэлийн гарч болох магадлал болон учруулж болох хохирлын хэмжээнд үнэлгээ өгөхдөө дараах байдлаар тооцно:

3.3.1. Компанийн үйл ажиллагаа явуулахад тулгарч болзошгүй эрсдэлүүдийг “Эрсдэлийн ангилал болон тодорхойлолт” /Risk Categorization and Definition/-ын аргыг ашиглан энэ аргачлалын 1 болон 2 дугаар хавсралтын дагуу компанийн газар, нэгж бүрээс судалгаа авах байдлаар тодорхойлно. Шинээр бий болж болзошгүй эрсдэлийг хавсралтад нэмж тодорхойлж болно.

(Энэ заалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

3.3.2. Компанийн эрсдэл даах сонирхол (Risk Appetite)-ыг энэ аргачлалын 3.3.1-т тодорхойлсон эрсдэлүүдийн гарах магадлал болон хор хөнөөлийг 1-ээс 5-ын хооронд үнэлгээ өгч, дараах хүснэгтийн дагуу эрэмбэлнэ:

Үнэлгээ	Эрсдэл гарах магадлал	Эрсдэлийн хор хөнөөл
1	Маш бага	Маш бага
2	Бага	Бага
3	Дунд	Дунд
4	Их	Их
5	Маш их	Маш их

3.4. Даатгалын бус эрсдэл гарах магадлал болон түүний хор хөнөөлийн үнэлгээний нийлбэр дүнг дараах хүснэгтийн дагуу удирдана:

Маш бага <5	Бага 5<x<6	Дунд 6<x<7	Их 7<x<8	Маш их 8<
Хүлээн зөвшөөрнө	Сайжруулах	Төсвөөр шийднэ, Хуваалцах	Бууруулна	Зайлхийнэ, Шилжүүлнэ, Хязгаарлана

3.5. Компанийн эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь “Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө”-г жил бүр гүйцэтгэх удирдлагаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

(Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмсэн)

Дөрөв. Эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан

4.1. Компани нь өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийж, үнэлгээний тайлан гаргана.

4.2. Эрсдэлийн үнэлгээний тайландаа компанийн дотоод хяналтын алба нь хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана.

4.3. Эрсдэлийн үнэлгээний тайланг компанийн Эрсдэлийн хороо болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, “Эрсдэлийн үнэлгээний



тайлангийн товч” болон дотоод хяналтын дүгнэлтийн хамт дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

(Энэ хэсгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

Тав. Бусад зүйл

5.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо энэ аргачлалын хэрэгжилтэд хяналт тавина.

5.2. Энэ аргачлалыг холбогдох хууль, журамтай нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг компани хариуцна. Энэ аргачлалыг шинэчлэн баталсан болон нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш 14 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.

5.3. Компани энэ аргачлалд тусгагдаагүй эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэхтэй холбоотой аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Хорооноос баталсан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам” болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

(Энэ хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан)

5.4. Компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд энэ аргачлалыг мөрдөж ажиллана.

5.5. Энэ аргачлалыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

Зургаа. Аргачлалын хавсралт

6.1. Хавсралт-1-“Үндэсний давхар даатгал ХК-ийн гадаад хүчин зүйлийн эрсдэлийн ангилал болон тодорхойлолт”-ын загвар

6.2. Хавсралт-2-“Үндэсний давхар даатгал ХК-ийн дотоод хүчин зүйлийн эрсдэлийн ангилал болон тодорхойлолт”-ын загвар

---oOo---

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН
ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛИЙН
АНГИЛАЛ БОЛОН ТОДОРХОЙЛОЛТ

Эрсдэлийн ангилал	Эрсдэл	Эрсдэлийн тодорхойлолт	Гарах магадлал (1-5)	Хор хөнөөл (1-5)	Эрсдэлийг хянах арга хэмжээ
1	2	3	4	5	6
Оролцогч талуудын эрсдэл	Давхар даатгагчийн эрсдэл	Давхар даатгагч даатгалын гэрээгээр хулээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх			
	Даатгагчийн эрсдэл	Даатгагч давхар даатгалын хураамжийг цаг тухайд нь төлөхгүй байх			
Улс төр	Улс төр, удирдлагын эрсдэл	Улс төрийн тогтвортгүй байдлаас хамааран удирдлага болон хүний нөөцөд өөрчлөлт орж, хэвийн үйл ажиллагаа тасалдах			
	Хувьцаа эзэмшигчийн эрсдэл	Улс төрийн тогтвортгүй байдлаас үүдэн хувьцаа эзэмшигч буюу Сангийн яам төсөв багасгах, үйл ажиллагааг хязгаарлах			
Хууль эрх зүйн орчны эрсдэл	Эрх зүйн актыг зөрчих эрсдэл	Компанийн үйл ажиллагаа нь эрх бүхий этгээдээс баталсан эрх зүйн актыг зөрчих, эсхүл шинээр хууль тогтоомж батлагдсанаас учрах эрсдэл			
Нийгмийн эрсдэл	Халдварт өвчин	Халдварт өвчнөөс шалтгаалан ажлын байрны хэвийн байдал, бизнесийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл			
Макро эдийн засаг	Инфляцын эрсдэл	Инфляциас үүдэлтэй хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэл			
	Валютын ханшийн эрсдэл	Гадаад гүйлгээ хийх тохиолдолд төгрөгийн ханш унах			
Санхүү, хөрөнгө оруулалтын эрсдэл	Арилжааны банкны эрсдэл	Мөнгөн хөрөнгө хадгалуулсан арилжааны банк эрсдэлд орох, татан буугдах			
	Хөрөнгө оруулалт, хүүгийн эрсдэл	Хөрөнгө оруулалтын өгөөж улс төр болон эдийн засгийн хямрал зэргээс шалтгаалан буурах			

---оо---



**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН
ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛИЙН
АНГИЛАЛ БОЛОН ТОДОРХОЙЛОЛТ**

Эрсдэлийн ангилал	Эрсдэл	Эрсдэлийн тодорхойлолт	Гарах магадлал (1-5)	Хор хөнөөл (1-5)	Эрсдэлийг хянах арга хэмжээ
1	2	3	4	5	6
Үйл ажиллагаа	Ур чадвартай ажилтнаа алдах эрсдэл	Мэргэжилтэн болон чадварлаг ажилтан ажлаас гарснаар компанийн хэвийн үйл ажиллагаа тасалдах			
	Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл	Ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад учрах эрсдэл			
	Ажилтны хариуцлагын эрсдэл	Ажилтан ажил үүргээ биелүүлэх явцдаа санаатай болон санамсаргүй алдаа гаргах			
	Сервер гаднын халдлагад өртөх эрсдэл	Сервер гаднын халдлагад өртсөнөөс хэвийн ажиллагаа тасалдах, зогсох, компанийн программ хангамж, техник тоног төхөөрөмж, мэдээллийн нэгдсэн систем, түүний аюулгүй байдалтай холбоотой үүсэж боловх эрсдэл			
	Ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн зэрүүний эрсдэл	Бизнес төлөвлөгөө хэрэгжээгүйгээс үүсэх эрсдэл			
Стратегийн эрсдэл	Нэр хүндийн эрсдэл	Гүйцэтгэх удирдлага, ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж компанийн нэр хүнд унах			
	Хөрөнгө оруулалт, хүүгийн эрсдэл	Хөрөнгө оруулалтыг эрсдэлтэй хэлбэрээр байршуулах, хүүгийн өгөөжийг буруу тооцоолох			
	Өрсөлдөгчийн эрсдэл	Өрсөлдөгч байгууллагуудаас муу стратеги ашигласнаас компанийн орлого буурах, зах зээлээ алдах эрсдэл			
Санхүүгийн эрсдэл	Төлбөрийн чадварын эрсдэл	Төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж чадахгүй тохиолдолд үйл ажиллагаа зогсох эрсдэл			
	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг хангахгүй байснаар төлбөрийн чадварын зохистой харьцааг бууруулах эрсдэл			



	Нөөц санг буруу тооцоолон нөхөн төлбөр олгох чадамжгүй болох эрсдэл	Нөөц санг буруу тооцоолон нөхөн төлбөр олгох чадамжгүй болох эрсдэл		
	Даатгалын төвлөрлийн эрсдэл	Даатгалын бүтээгдэхүүний хэт төвлөрлөөс үүдэн нэг эсрэлээс хамааран их хэмжээний хохирол гарах эрсдэл		
	Зээлийн эрсдэл	Муу авлага үүсэж, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд нөлөөлөх		
Комплаенс эрсдэл	Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын эрсдэл	Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангаж ажиллаагүйн улмаас торгуулийн арга хэмжээ болон тусгай зөвшөөрөл цуцлах хүртэл арга хэмжээ авах эрсдэл		
	Дотоод дүрэм, журам мөрдөхгүй байх эрсдэл	Дотоод дүрэм, журмыг мөрдөж ажиллаагүйгээс үүдэн хэвийн үйл ажиллагаа доголдох эрсдэл		
	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл	Компанийн үйл ажиллагаа нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлснээс үүсэх эрсдэл		

---oOo---

